

Орон нутгийн иргэд, Эмэгтэйчүүдийн газрын эрх: Орон нутгийн манлайлагч нарыг чадавхижуулах нь

Олон улсын Цахим
(Вэбинар) хурлын
тайлан



Эмэгтэйчүүдийн Газар Эдэлбэрийн Эрхийн Баталгаат Байдал төсөл нь (ЭГЭЭББ) сүүлийн таван жилийн хугацаанд Монгол, Танзани улсуудад уул уурхайн нөлөөнд өртсөн нүүдэлч малчин иргэдийн жендер болон газрын харилцааны хамаарлыг судаллаа. Тус ажлын үндсэн зорилго нь орон нутгийн иргэдтэй урт хугацаанд хамтран ажиллаж, тэдний чадавхийг хөгжүүлснээр эмзэг бүлгийнхний газрын эрхийг хамгаалах явдал юм. Ингэснээр нутгийн иргэдийн газрын эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлж, газар эдэлбэрийн засаглалд хүйсийн тэгш байдлыг нэвтрүүлэх юм.

Төслийн хүрээнд орон нутгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс бүрдсэн манлайлагч нарын багийг чадавхижуулсан нь эмэгтэйчүүд төдийгүй, бүхий л иргэдийн дунд өөрчлөлт авчирч болохыг харууллаа. Манлайлагч нар сургалтын хөтөлбөрт хамрагдснаар эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалах ажлуудад түлхэц болж, ялангуяа иргэдийн газрын эрхийг хамгаалах, сайжруулах хүрээнд бодит, үр дүнтэй ажлуудыг хийж эхлээд байна. ЭГЭЭББ төслийн арга барил нь иргэдийн дундах хуучны, үеэ өнгөрөөсөн хэв жаяг болон дэлхий дахины асуудал болсон газрын түрэмгийлэлтэй тэмцэхэд иргэдийг хүчирхэгжүүлж, энэ ажилд бодитоор түлхэц үзүүлж байгаа нь нотлогдож байна. Төсөл хэрэгжсэн газруудад эмэгтэйчүүдийн манлайлалын шинэ орон зай бий болж, өрхийн түвшин дэхь хуучны хэв жаяг өөрчлөгдөн, хүйсийн тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт дээшилсэн байна.

Тус олон улсын цахим хурлын үеэр, ЭГЭЭББ төслийн багийн ахлагч Элизабет Далий төслийн талаар танилцуулан, гарсан үр дүнг нэгтгэн толилуулж, төслийг өөр газруудад түгээн дэлгэрүүлэх боломжтой талаар дурдлаа. Харин Олон Улсын Газрын Эвслийн захирал Майкл Тэйлор дэлхий даяарх нийтийн эзэмшлийн газарт түшиглэн амьдардаг хэдэн түм иргэдийн төлөө шударга, хариуцлагатай газрын засаглалыг хөгжүүлэхэд тус төсөл нь бодит хувь нэмэр оруулах бүрэн боломжтойг цохон тэмдэглэлээ. ЭГЭЭББ төслийн багийн гишүүд болох Жоис Дакару, (Танзани улсын Хакамадини байгууллага) болон Янсанжавын Нарангэрэл (Монгол улс дахь Хүн Төвтэй Байгаль Хамгаалал байгууллага) нар төсөл болон сургалтаас гарсан үр дүнгийн талаар өөрсдийн орны жишээнээс танилцуулж, төслийг цаашид түгээн дэлгэрүүлэх боломж байгаа талаар саналаа хуваалцлаа.

Хурлыг удирдсан:

- **Кристофер Тэннэр, Мокоро байгууллага**

Илтгэл тавьсан:

- **Элизабет Далий , Мокоро байгууллага**
- **Майкл Тэйлор, Олон Улсын Газрын Эвсэл**
- **Жоис Дакару , Хакамадини байгууллага**
- **Янсанжав Нарангэрэл , Хүн Төвтэй Байгаль Хамгаалал**

Цахим хурлын бичлэгийг эндээс харна уу : <https://youtu.be/Grn83dofH0>

Төслөөс гарсан гол үр дүнгүүд

- Газрын засаглал дахь эмэгтэйчүүдийн оролцоо дээшилсэн
- Эмэгтэйчүүдийн газрын эрхийг дэмжсэнээр нутгийн нийт иргэдийн газрын эрхийг хамгаалах боломжтой
- Манлайлагч нарын газар болон жендертэй холбоотой хуулийн мэдлэг 50%-иар дээшилсэн
- Хүйсийн тэгш байдлаас үүдэлтэй хүчирхийлэл, жендерийн тогтсон хэв жаягуудад эерэгээр нөлөөлж чадсан
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдэл сайжирсан – шууд бус үр дүн
- Батлагдсан арга барил – цаашид түгээн дэлгэрүүлэн хэрэгжүүлэхэд бэлэн

ЭГЭЭББ төсөл нь орон нутгийн түвшинд иргэдтэй болон нутгийн захиргаатай харилцан хамтын ажиллагааг урт хугацаанд үргэлжлүүлэх зорилт тавин ажилласан. ЭГЭЭББ төслийн манлайлагч нарын сургалтын хөтөлбөр нь 2 жилийн турш оролцооны аргаар явуулсан суурь судалгаанаас урган гарсан учир нотолгоон дээр суурилсан үр дүнд хүрэхийг зорьсон. Иймээс сургалтын хөтөлбөр нь тухайн орон нутгийн хэрэгцээнд суурилсан, өөр газруудад авч хэрэгжүүлж болохуйц загвараар боловсруулагдсан юм.

ЭГЭЭББ төсөл эхнээсээ орон нутгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийг хамтад нь эрх тэгш оролцуулж ирсэн. ЭГЭЭББ төслийн баг манлайлагч нарыг хувь хүнийх нь зүгээс болон баг хамт олон болохын хувьд тэдний итгэл үнэмшлийг ахиулах үүднээс харилцан бие биенээ дэмжсэн эрүүл орчинг буй болгохыг зорьж ажиллаа. Сургалтын үеэр олон төрлийн оролцооны арга техникүүдийг нийтийн хэлэлцүүлэг болон хүйсээр баг болгон хуваан ажиллуулахад хэрэглэж байсан.

Эмэгтэйчүүдийн газрын эрхийг хамгаалах үйлс нь иргэдийн газрын эрхийг баталгаажуулах ажил болсон юм. Сургалтын хөтөлбөрт хамрагдаж чадавхижсан манлайлагч нар жендерийн тэгш эрхтэйгээр байгалийн нөөцөө хамтын хүчээр хамгаалахад орон нутгийн удирдлагуудаа дэмжин ажиллаж байна.

ЭМЭГТЭЙЧҮҮД БОЛОН ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ГАЗРЫН ЭРХ

ОРОН НУТГИЙН МАНЛАЙЛАГЧ НАРЫГ ЧАДАВХИЖУУЛАХ НЬ

Эмэгтэйчүүдийн
Газар Эдэлбэрийн
Баталгаат Байдал
(ЭГЭЭББ) төслийн 5
жилийн үр дүн

Гол үр дүнгүүд:

*Манлайлагч нарын газар
болон жендерийн сургалт нь
хүйсийн тэгш бус байдлаас
үүдэлтэй хүчирхийлэл зэрэг
жендерийн бусад хэм
хэмжээнд нөлөөлж чадсан*

Олон Улсын Цахим Хурлын хураангуй

1) ЭГЭЭББ ТӨСЛИЙН ЖЕНДЕР БОЛОН ГАЗРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРӨӨС ГАРСАН НЭН ТҮРҮҮНИЙ ҮР ДҮН ЮУ БАЙВ?

- Эмэгтэй манлайлагч нар хурлын үеэр өөртөө итгэлтэйгээр саналаа хэлдэг болж, нутгийн уугуул ахлагч нар тэднийг дэмжин ажилладаг болсон.
- Эмэгтэйчүүд орон нутгийн сонгуульд идэвхитэй оролцон, ялангуяа Танзанид эрэгтэй манлайлагчид тэднийгээ дэмжин ажиллаж байна.
- Эмэгтэйчүүдийн газрын эрхийг хамгаалах үйлс нь бүх иргэдийн газрын эрхийг хамгаалах ажил болоод байна. Монголын манлайлагч нар нутгийн иргэдтэйгээ хамтран уул уурхайн компаниудад шаардлага хүргүүлж, шийдүүлэн ажиллаж эхлээд байна. Тэрчлэн хамтран газар нутаг, бэлчээрээ хамгаалж, орон нутгийн түвшинд гарч буй аливаа шийдвэр, төлөвлөгөөг жендерийн мэдрэмжтэй боловсруулахад дэмжлэг болж байна.

2) ЭГЭЭББ ТӨСЛИЙН ЭНЭХҮҮ АРГА БАРИЛ НЬ ГАЗРЫН ЭРХЭЭ ХАМГААЛАХАД ЭРЭГТЭЙЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ ДЭЛХИЙ ДАХИНЫ ҮЙЛСЭД ЯМАР ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ БАЙНА ВЭ?

- Дэлхий дахинд орон нутгийн иргэдийн газрын эрхийг бүх нийгээр хүлээн зөвшөөрөх хэрэгцээ шаардлага маш их байна. Гэсэн хэдий ч энэ чиглэлийн Тогтвортой Хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарч байгаа үр дүнгүүдийн нотолгоо түн бага хэвээр байна.
- Нутгийн иргэдийн газрын эрхийг баталгаажуулах үйл ажиллагааг хэрхэн өргөжүүлэх вэ? ЭГЭЭББ төсөл нь орон нутгийн иргэд хамтын хичээл зүтгэлээрээ хэрхэн нийгмийн эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалж болохыг харууллаа.
- ЭГЭЭББ төсөл нь нутгийн эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу хүмүүс хамтран үндсэн суурь эрх болсон газрын эрхээ хэлэлцэн шийдэж, шинэ боломжуудыг өөрсдөдөө буй болгож байгаа нь ардчилалыг бүтээн байгуулж байгаа тод жишээ юм.
- Эмэгтэйчүүдийн газрын эрхийг баталгаажуулах нь тэдний эсрэг ялгаварлан гадуурхах үйлсийн төлөөх нэг алхам болж байгаа юм. Эмэгтэй манлайлагчдыг төрүүлж байгаа ажил нь орон нутагт хүйсийн тэгш эрхтэй холбоотой урт хугацааны үр дүнг эхлүүлж байгаа хэрэг юм.

3) ЭГЭЭББ ТӨСЛИЙН БАГ МАНЛАЙЛАГЧ НАРЫН ГАЗАР БОЛОН ЖЕНДЕРИЙН ТАЛААРХ ХУУЛИЙН МЭДЛЭГИЙН ТҮВШИН ДЭЭШИЛСНИЙГ ХЭРХЭН ХЭМЖСЭН БЭ?

- Хэд хэдэн цуврал санал асуулгыг системтэйгээр явуулснаар ЭГЭЭББ төслийн баг сургалтын хөтөлбөрийн дараа манлайлагч нарын хуулийн мэдлэг 50% дээшилснийг олж тогтоосон. Эмэгтэй манлайлагч нарын хууль эрх зүйн мэдлэг 62%-иар дээшилсэн бол эрэгтэйчүүдийнх 37%-иар ахисан байна.
- Эрэгтэй, эмэгтэй манлайлагч нар оролцсон газар болон жендерийн сургалт нь нийгэмд хэвшил болсон ёс жаягт өөрчлөлт оруулсан. Хүйсийн тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийлэлд хандах тэдний хандлага өөрчлөгдөхөөс гадна эдийн засагт ч гэсэн ахиц авчирсан байна.

4) ЭГЭЭББ ТӨСӨЛ МОНГОЛ БОЛОН ТАНЗАНИ УЛСУУД ДАХЬ ЖЕНДЕРИЙН ТОГТСОН ХЭВ ЖАЯГТ ЯМАР ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БЭ?

- Дүрийн тоглолт зэрэг оролцооны аргуудыг ашигласнаар сургалтын үеэр жендерт суурилсан хүчирхийллийн талаар манлайлагчид илүү нээлттэй ярилцаж чадсан.
- Төсөл хэрэгжсэн газруудад залуу эрчүүдийн дундах гэрийн ажил нь зөвхөн эмэгтэй хүний хариуцлага гэсэн үзэл нь өөрчлөгдөн, хамтран хийдэг болсон. Танзанийн кэйз судалгаагаар өмнө нь хурлын үеэр эмэгтэйчүүд сандалаа эрэгтэй хүмүүст тавьж өгдөг байсан бол манлайлагч нар үүнийг нэгэн дуугаар ялгаварлан гадуурхалт гэж үзэн энэ дадлыг бүрмөсөн халахыг санал нэгтгэжээ уриалж байна.
- Монголд манлайлагч нар жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдод туслалцаа үзүүлж байна. Тэд санаачлан хүчирхийллийн үед хандах агентлаг байгууллагуудын утасны жагсаалтыг томоор хэвлэн багийн төвийн хананд байрлуулжээ. Цаашлаад, манлайлагч нар хүчирхийллийн өөр хэлбэрүүд болох эдийн засаг, сэтгэл санааны хүчирхийллийн талаар мэдлэг мэдээлэлээ нэмэгдүүлж, эмзэг бүлгийн эрэгтэйчүүдийн асуудлыг хөнддөг боллоо.

5) ЭГЭЭББ ТӨСӨЛ НЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ ЧАДСАН УУ?

- ЭГЭЭББ төслийн манлайлагч нарын сургалт нь эмэгтэйчүүдэд бусадтай ижил тэнцүү нөхцлөөр хангагдах эрхийг шаардах итгэлийг өгсөн. Тухайлбал, Танзанид эмэгтэйчүүд ашигт малтмал зарахад эрэгтэйчүүдийн зардаг үнээс доогуур өгдөг нь уламжлал болсон зүйл. Харин өнгөт чулуу түүдэг эмэгтэйчүүдийн нөхрүүдийг оролцуулснаар эмэгтэйчүүд үнэ унасан үед чулуугаа наймалцалгүй, үнэ ихсэх боломжит нөхцөлийг хүлээдэг болжээ.
- Монголын нүүдэлч малчдын амьжиргаа бэлчээртэй шууд холбоотой учир газрын маргаан нь тэдний амьдралд чухал нөлөөтэй. Сургалтад хамрагдсан манлайлагч нар уул уурхайн компанитай хэлэлцээр хийж, хэрвээ лизенз болон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл байхгүй бол тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч байна. Газрын эрхээ баталгаажуулсан нүүдэлч малчдын итгэл үнэмшил сайжирч орлогын эх үүсвэрүүдийг буй болгож байна.

5) ЭГЭЭББ ТӨСЛИЙН АРГА БАРИЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ, ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ ХЭР БАЙНА ВЭ?

- Танзанийн хөрш зэргэлдээх суурингаас ЭГЭЭББ төслийн сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах хүсэлт ирсэн.
- ЭГЭЭББ төсөл орон нутгийн түвшнээс хальж, Монгол Улсын Газрын Албатай (Газар Зохион Байгуулалт, Геодизи, Зураг Зүйн Газар) хамтран Сумын Нутаг Дэвсгэрийн Хөгжлийн Төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоотой, жендерийн тэгш эрхтэй зарчмуудыг тусгасан шинэ зөвлөмжийг боловсруулсан. Энэ нь ЭГЭЭББ төсөл сонгогдсон орон нутагтаа амжилттай хэрэгжээд зогсохгүй эмэгтэйчүүдийн газрын эрхийг хамгаалахад өргөн цар хүрээгээр, үр дүнтэй ажиллах бүрэн боломж байгааг харуулж байна.

Илтгэгч нарын хурлын үеэр тэмдэглэн хэлсэн ишлэлүүдээс



“МАНАЙ ЭГЭЭББ ТӨСЛИЙН БАГ МАНЛАЙЛАГЧ НАРЫГ ХУВЬ ХҮНИЙНХ НЬ ЗҮГЭЭС БОЛОН БАГ ХАМТ ОЛОН БОЛОХЫН НЬ ХУВЬД ТЭДНИЙ ИТГЭЛ ҮНЭМШЛИЙГ АХИУЛАХ ЗОРИЛГООР ХАРИЛЦАН БИЕ БИЕНЭЭ ДЭМЖСЭН ЭРҮҮЛ ОРЧИНГ БҮЙ БОЛГОХЫГ ЗОРИН АЖИЛЛАСАН. ЭНЭ НЬ ТӨСЛИЙН МАШ ЧУХАЛ ЕЛЕМЕНТ БАЙСАН. ОЛОН ҮР БҮТЭЭЛТЭЙ, ИДЭВХИТЭЙ БҮЛГИЙН УУЛЗАЛТУУД БОЛЖ БАЙЛАА. БИД ДҮРИЙН ТОГЛОЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХҮЙСЭЭР НЬ ХУВААН ЭСВЭЛ ХОЛИМОГ БАГ БҮРДҮҮЛЖ ХЭЛЭЛЦДЭГ БАЙСАН. БИД ОЛОН ТӨРЛИЙН ОРОЛЦООНЫ АРГУУДЫГ АШИГЛАН ЖИЖИГ БҮЛГЭЭР БОЛОН НИЙТЭЭРЭЭ АСУУДЛАА ХЭЛЭЛЦДЭГ. ТЭРЧЛЭН БИД НЭГ САНАА НӨГӨӨГӨӨС АЯНДАА УРГАН ГАРЧ АСУУДЛЫН МӨН ЧАНАРЫГ ШИЙДЭХ АРГЫГ ХҮРТЭЛ АШИГЛАЖ БАЙЛАА.

- ЭЛИЗАБЭТ ДАЛИЙ, МОКОРО



“[ЭГЭЭББ ТӨСЛИЙН БАГ] ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ДУНД БАЙДАГ СЭТГЭЛ ЗОВООСОН, ЭМЗЭГ АСУУДЛУУДЫГ ХҮРТЭЛ ОРХИГДУУЛААГҮЙ. ЭНЭ БҮХЭНТЭЙ ТА НАР ТУЛЖ, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ЧИГЛҮҮЛЖ, ИНГЭХ ЯВЦДАА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГАЗРЫН ЭРХИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ДУНДАХ ЭСЭРГҮҮЦЭЛТЭЙ ТУЛГАРЧ БАЙЖЭЭ”.

- МАЙКЛ ТЭЙЛОР , ОЛОН УЛСЫН ГАЗРЫН ЭВСЭЛ



“БИД СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРӨӨ ЭХЭЛЖ БАЙХ ТЭР ҮЕД ЭМЭГТЭЙЧҮҮД ЯРЬДАГҮЙ, ЯРИХ ЗҮЙЛ БАЙСАН Ч ГАР ӨРГӨН ХЭЛДЭГҮЙ БАЙСАН. ЭНЭ НЬ МАНАЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫН НЭГ ХЭСЭГ Л ДЭЭ. УЧИР НЬ ЭМЭГТЭЙ ХҮН ЭРЭГТЭЙ ХҮНИЙ ӨМНҮҮР ОРЖ АМ БУЛААЛДАН ЯРЬДАГҮЙ, МАРГАДАГҮЙ. ИНГЭЭД БИД ТЭДНИЙ ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛ ОЛГОХ АЖЛУУДЫГ ХИЙЖ ЭХЭЛСНЭЭР ТЭД Ч ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ БОЛСОН. ТЭРЧЛЭН НАСТАЙ ХҮМҮҮС ЭМЭГТЭЙЧҮҮД САНАЛАА ХЭЛЖ, ШИЙДВЭР ГАРГАЛТАД ОРОЛЦОХЫГ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ БОЛСОН”.

- ЖОИС ДАКАРУ, ХАКАМАДИНИ, ТАНЗАНИ УЛС



“МАНАЙ ОРОЛЦОГЧИД ХҮЙСИЙН ТЭГШ БУС БАЙДЛААС ҮҮДСЭН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН, ХОХИРСОН НЭГЭНДЭЭ ТУСАЛЖ ЭХЭЛСЭН. ТУХАЙЛБАЛ, МАНАЙ НЭГ ЭРЭГТЭЙ МАНЛАЙЛАГЧ ӨӨРИЙН САНААЧЛАГААР ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮМҮҮС ХАНДАХ ГАЗАР БОЛОН УТАСНЫ ДУГААРТАЙ САМБАРЫГ ТОМООР ХИЙН БАГИЙН ТӨВИЙН ХАНАНДАА БАЙРШУУЛСАН. УЧИР НЬ ЖИЖИГ ЦААСАН ДЭЭР ХЭВЛЭЖ БИЧСЭН ЭДГЭЭР УТАСНЫ ДУГААРУУДЫГ ЭМЭГТЭЙЧҮҮД ТЭР БҮР ХАРААД БАЙДАГҮЙН ШАЛТГААН НЬ БУСДААС САНАА ЗОВСОНДОО ТЭР Л ДЭЭ. ЭНЭ ӨӨРӨӨ ИХ ЭМЗЭГ АСУУДАЛ ШҮҮ ДЭЭ. ИНГЭЭД ТОМООР ХЭВЛҮҮДЭЭД ӨЛГӨСНИЙГ ХҮН БҮР БУСДАД АЖИГЛАГДАХГҮЙГЭЭР ХАРЖ БОЛОХООР БОЛЖЭЭ. ТЭРЧЛЭН МАНЛАЙЛАГЧИД ИРГЭДИЙГ ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГААТАЙГАА ОРОЛЦООТОЙ, ЖЕНДЕРИЙН ТЭГШ ЭРХТЭЙ БАЙДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХАД ТУСАЛЖ БАЙНА. ОРОН НУТГИЙН ЗАХИРГААНЫХАН БИДЭНД СУРГАЛТАД СУУСАН МАНЛАЙЛАГЧИД АЛИВАА ШИЙДВЭР ГАРГАХДАА БОЛОН ТӨЛӨВЛӨЛТӨД ЖЕНДЕРИЙН АСУУДЛЫГ ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХЫГ САНУУЛДАГ БОЛСОН ГЭЖ БАЙСАН.”

- ЯНСАНЖАВЫН НАРАНГЭРЭЛ, ХҮН ТӨВТЭЙ БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, МОНГОЛ

